

“ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ТАЛААРХ ХҮН АМЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ-ЫН СУДАЛГАА 2010”

ТОВЧ ХУРААНГУЙ

Уг судалгаа нь хүн амын дунд эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх, амьдралын эрүүл хэв маягыг төлөвшүүлэх чиглэлээр ММСС-ийн Эрүүл Мэнд төслөөс үндэсний түвшинд өргөн хүрээгээр явуулж буй мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг эрчимжүүлэх, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох зорилготойгоор анх удаа явуулсан үндэсний хэмжээний судалгаа боллоо.

Энэхүү судалгааны асуумж материалыг Монголын МСС-гийн гадаад, дотоодын зөвлөхүүд хамтарч ажиллахын зэрэгцээ, дотоодын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор Монгол улсад өмнө хийгдсэн ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын удаа дараагийн шаталсан судалгаанаас гарсан гол үр дүнгүүдийг гүнзгийрүүлэн судлах, улмаар эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах арга зам, чиглэл, зорилтот бүлгүүдийг нарийвчлан тодорхойлохоор тусган эцэслэн боловсруулсан болно. Судалгаагаар дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

1. ХБӨ, тэдгээрийн зан үйлийн анхдагч болон хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн талаарх хүн амын мэдлэг, хандлага, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох
2. Зүрх судасны өвчин, чихрийн шижин, эдгээрээс урьдчилан сэргийлэх, хянах, хүндрэлээс сэргийлэх аргуудын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох
3. Хөх, умайн хүзүүний хавдар, эдгээрээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэлбэрүүдийн талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох
4. Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр үндэсний түвшинд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны суурь үзүүлэлтүүдийг тогтоох

Судалгаанд Монгол улсын 20 аймгийн 24 сум, Улаанбаатар хотын 7 дүүргийн 18 хороодын 15-64 насны нийт 3450 хүн хамрагдлаа. Судалгааны мэдээлэл цуглуулах ажил улс орон даяар 2010 оны 11-р сарын 5-аас 12-р сарын 5-ны өдрүүдэд явагдлаа.

Судалгааны мэдээллийн баазыг EPI DATA 3.1 программд мэдээллийн сан үүсгэн тоон мэдээллийг оруулав. Мэдээллийн үр дүнгийн боловсруулалтыг SPSS18 программын комплекс түүврийн нэмэлт модуль бүхий хувилбарыг ашиглан хийв. Судалгааны үр дүнд хүн амын болон түүврийн жинлэлтийн хүчин зүйлүүдийг тооцооноор судалгааны насны Монгол улсын нийт хүн амыг төлөөлөхүйц үр дүнгийн үзүүлэлтүүдийг гаргав. Хүн амын мэдлэгийн түвшин, хандлагыг **давтамж** ба **дундаж** үзүүлэлтээр тооцоолов. Үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (давтамжийн хэлбэлзэх хязгаар) болоод бүлгүүдийн (нас, хүйс, хот хөдөө) ялгааг тодорхойлоход **95 хувийн итгэх хязгаар (95%CI)**-ын хэлбэлзлийн утгуудыг ашиглав.

ХБӨ-ний талаарх ерөнхий мэдлэг хандлагыг судалсан дүнгээр хүн амын (81.3%) халдварт бус өвчин нь хүнээс хүнд халдварладаггүй өвчин гэсэн зөв ойлголттой

хэдий ч 4 хүн тутмын нэг нь (19.7%) энэ талаар тодорхой мэдэхгүй буюу буруу ойлголттой байна. Судалгааны насны хүн амын (91.6%) дийлэнх нь халдварт бус өвчнүүд нь монголчуудын дунд түгээмэл тохиолдож буй гэдэгтэй санал нийлж байгаа хэдий ч, тэдний талаас илүү хувь нь (65.7%) халдварт бус өвчнүүд нь халдварт өвчинтэй харьцуулахад аюул багатай гэж үздэг сөрөг хандлагатай байна.

ХБӨ-ний зан үйлийн анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн нэг нь архины зохисгүй хэрэглээ юм. Судалгааны хүн амын 90.1 хувь Монголчууд архи согтууруулах ундааг хэрэглэхдээ ихэвчлэн нэг дор их хэмжээгээр уудаг гэдэгтэй санал нийлж байна. Архи согтууруулах ундаа хэрэглэгсдийн 78.2 хувь нь найз нөхдийн хамт архи уудаг ба энэ нь тэднийг архи уухад хүргэдэг хамгийн гол шалтгаан болдог гэжээ. Харин өөрт тулгарсан асуудлаа мартахын тулд уух нь 15-24 насныхны 13.9 хувь, 35-44 насныхны 10.3 хувьд хамгийн түгээмэл тохиолддог байна. Архи, согтууруулах ундаа хэрэглэгсдийн 66.2 хувь нь уух хэмжээгээ багасгах шаардлагатай байгаагаа мэддэг байна.

Хүн амын дийлэнх нь тамхи эрүүл мэндэд хортой гэж мэддэг ч, тэдний 7.7 хувь нь хоногт хайрцгаас олныг татвал, 8.5 хувь нь зөвхөн өдөр бүр тамхи хэрэглэвэл эрүүл мэндэд хор нөлөө үзүүлнэ гэж ойлгодог байна. Судалгааны хүн амын 99.4 хувь нь бусдын дэргэд тамхи татах нь тэдний эрүүл мэндэд нөлөөлнө гэж үздэг ч тэдний 17.9 хувь гэрт нь хэн нэгэн тамхи татах нь саад болдоггүй, 37.1 хувь нь саадтай санагддаг ч гэрт нь хэн нэгэн тамхи хэрэглэхийг зөвшөөрдөг байна.

Судалгааны хүрээний хүн амын талаас илүү хувь (57% ба 62.3%) жимс, ногоог өдөр бүр хэрэглэх нь “чухал”, зөвхөн 25 орчим хувь нь “маш чухал” гэж үздэг байна. Эрэгтэйчүүд жимс, хүнсний ногооны өдөр тутмын хэрэглээнд бага ач холбогдол өгдөг ба энэ нь хот, хөдөөгийн хүн амд ч ижил хандлага ажиглагдаж байв. Хүн амын 69.2 хувь “үнэ өндөр”, 32.3 хувь “импортын хүнсний аюулгүй байдалд итгэдэггүй”, харин хөдөөгийн хүн амын 26 хувь нь “жимс, хүнсний ногооны хангамж хүртээмж муу” зэрэг шалтгааны улмаас жимс, ногоог хангалттай хэмжээгээр хэрэглэхгүй байна.,

Хүн амын ихэнх нь (92.1%) хоногт хэрэглэх давсны ихэнхийг, тухайлбал хоол цайндаа нэмж хэрэглэх байдлаар ил, зөвхөн 4.4 хувь нь нь талх, хиам, жигнэмэг зэрэг боловсруулсан бусад хүнсээр дамжуулан далд хэлбэрээр тус тус авдаг гэжээ. Давс агуулсан хүнсний бүтээгдэхүүний талаарх хүн амын мэдлэгийн түвшин хангалтгүй буюу тухайлбал, цагаан талх дунд зэрэг давстайг 2 хүн тутмын 1, кетчуп давс ихтэй хүнс гэж 3 хүн тутмын 2, харин шарсан төмс давс ихтэй талаар 10 хүн тутмын 6 нь тус тус мэддэггүй байна.

Судалгааны насны 4 хүн тутмын 1 нь (25.9%) дасгал, хөдөлгөөнийг ямар давтамжаар хийх талаар ташаа ойлголттой байна. Хүн амын 28.1 хувь хэрхэн идэвхитэй хөдөлгөөнтэй байх талаар сайн мэддэггүй, 29.8 хувь нь цаг зав гардаггүй, 24.3 хувь дасгал хөдөлгөөн хийх сонирхолгүй гэжээ. Гэвч, хүн амын талаас илүү хувь нь (57%) сүүлийн 6 сард биеийн жингээ хэмжиж үзжээ. Нийт хүн амын 34.5 хувь нь биеийн жингээ хянах нь “маш чухал” гэж үздэг бөгөөд, эмэгтэйчүүдийн дунд (42.8%) энэ хандлага эрэгтэйчүүдээс 16.8 хувиар илүү байв.

Судалгааны хүрээний 2 хүн тутмын нэг нь цусны даралтын талаар огт мэдэхгүй (17.9%) эсвэл сонссон төдий (29.8%) байна. Эрэгтэйчүүдийн мэдлэгийн түвшин эмэгтэйчүүдээс харьцангуй доогуур байна. 35-аас дээш насныхны 75.7 хувь ер нь цусны даралтыг тогтмол хянуулах шаардлагатай гэж үздэг ч, тэдний 44.9 хувь

“өөрт нь тийм ч чухал гэж боддоггүй”, 28.8 хувь “өөрийгөө хэмжүүлэх шаардлагатай гэж мэдээгүй”, 17.1 хувь “цаг зав гардаггүй” тул цусны даралтаа тогтмол хэмжүүлж чаддаггүй гэжээ.

Давс ихтэй хоол хүнсний хэрэглээ цусны даралтад нөлөөлдөг талаар судалгаанд оролцогчдын 5 хүн тутмын 1 нь (23.5%) мэддэггүй, ялангуяа энэ талаарх ойлголт эрэгтэйчүүдэд хангалтгүй байна. Цусны даралт бууруулах аргад эм хэрэглэх үзэл давамгайлсан (96.8%) байгаа ба 4 хүн тутмын 1 нь (25.6%) биеийн жингээ бууруулах, 5 хүн тутмын 1 нь (20.3%) хооллолтын хэв маягаа өөрчлөх, 10 хүн тутмын 1 нь (13.7%) идэвхитэй хөдөлгөөнтэй байх зэрэг нь цусны даралтыг бууруулахад нөлөөлөхгүй гэж үздэг “сөрөг” хандлагатай байна.

ХБӨ-ний анхдагч болон хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн талаар хүн амын нийтлэг хандлагыг судалсан дүнгээр, нийт хүн амын 72.2 хувь архийг хэтрүүлэн хэрэглэх нь, 38.4 хувь тамхи хэрэглэх нь эрүүл мэндэд “маш аюултай” гэж тус тус үздэг байна. Архи, тамхины хэрэглээний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаарх үзэл бодол аль ч нас, хүйсийн хүмүүст ижил түвшинд байна. Харин хотын хүн амд архи, согтууруулах ундааг өдөр бүр хэрэглэх нь “маш аюултай” гэсэн эерэг “хандлага” хөдөөгийнхнөөс 14.9 хувиар илүү байна.

Жимс хүнсний ногоо бага хэрэглэх нь эрүүл мэндэд “аюултай” гэж хүн амын зөвхөн 29.2 хувь үздэг байна. Харин нийт хүн амын 18 хувь, үүнээс эрэгтэйчүүдийн 22.7 хувь нь жимс хүнсний ногоо бага хэрэглэх нь эрүүл мэндэд “ямар ч аюулгүй” гэж үздэг “сөрөг” хандлагатай байна. Давс ихтэй хоол хүнсний эрүүл мэндийн сөрөг нөлөөний талаар хүн амын 80 гаруй хувь нь “зөв” хандлагатай хэдий ч, эрэгтэйчүүдийн энэ талаарх ойлголт, хандлага дутмаг байна

Судалгааны хүрээний 5 хүн тутмын 1 нь (19.9%) хөдөлгөөний хомсдол нь эрүүл мэндэд “маш аюултай” гэж үздэг байна. Түүнчлэн хүн амын ихэнх нь (83.9%) илүүдэл жинтэй байх нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үздэг эерэг хандлагатай байна. Харин, эрэгтэйчүүдийн 21.9 хувь “илүүдэл жин” нь эрүүл мэндэд ямар нэг нөлөөгүй эсвэл “бага зэрэг” сөргөөр нөлөөлнө гэж үзэж байсан нь энэ талаарх эерэг хандлага бүхий үзүүлэлт эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин бага байв.

Зүрх судасны өвчин (ЗСӨ), цус харвалтын талаар хүн амын талаас илүү хувь нь (53% ба 55.95) “мэдэхгүй” буюу “сонссон төдий” ойлголттой, энэ талаарх эрэгтэйчүүдийн ойлголт эмэгтэйчүүдээс харьцангуй доогуур байна. Хүн амын 83.6 хувь ЗСӨ, цус харвалтын тархалт нэмэгдэж байгаа гэж үздэг ч, зөвхөн 13.6 хувь нь өөрийгөө ЗСӨ-өөр өвчилж болзошгүй гэж санаа зовдог, тал хувь нь (54.9%) энэ талаар “хааяа боддог”, харин 31.5 хувь нь “огт санаа зовдоггүй” байна.

Монгол улсын 10 хүн тутмын 1 нь (10.5%) ЗСӨ – өөс урьдчилан сэргийлэх боломжтой талаар мэддэггүй буюу буруу ойлголттой байна. Энэ талаар буруу ойлголттой 15-24 насныхан бусад насны хүмүүсээс 2 дахин их байна. Түүнчлэн, тамхи таталт, бухимдал, илүүдэл жин, ахимаг нас нь ЗСӨ - өөр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлэхгүй гэсэн “ташаа” ойлголттой хүн амын эзлэх хувь 15 – 34 насны хүн амын дунд харьцангуй түгээмэл байв.

Хүн амын 65.3 хувьд үүнээс эрэгтэйчүүд, хөдөө орон нутгийн хүмүүс чихрийн шижингийн талаар мэдлэг муутай байв. Судалгааны хүрээний хүн амын 10 хүний зургаа нь (66.3%) чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх боломжтой гэсэн зөв ойлголттой байхад 10 хүний хоёр нь (22.2%) энэ талаар мэдэхгүй, 10 хүний нэг нь (11.5%) урьдчилан сэргийлэх боломжгүй гэсэн буруу ойлголттой байна. Чихрийн шижингээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар 10 хүний гурав нь (26.4%) мэдэхгүй байна.

Манай улсын 30-аас дээш насны 4 эмэгтэй тутмын 1 нь хөхний хавдрын талаар огт мэдэхгүй, 3 эмэгтэйн 1 нь зөвхөн сонссон төдий байгаа ба зөвхөн 7.6 хувь нь хөхний хавдрын талаар сайн мэддэг байна. Судалгааны насны эмэгтэйчүүдийн 50,9 хувь нь гэр бүлийн хэн нэгэн нь хөхний хавдраар өвдчих бий гэж огт санаа зовдоггүй байна.

Эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (57,6%) умайн хүзүүний хавдрын талаар огт мэддэггүй буюу сонссон төдий байна. 30-аас дээш насны эмэгтэйчүүдийн 61,8 хувь нь сүүлийн 3 жилд умайн хүзүүний эсийн шинжилгээний сорил хийлгээгүй ба тэдний талаас илүү хувь нь (63,1%) сорил хийлгэх шаардлагатай гэж мэдээгүй гэжээ. Судалгааны насны эмэгтэйчүүдийн 28,8 хувь вакцин хийлгэсэнээр умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх боломжгүй гэж ойлгодог ба 55,9 хувь нь энэ талаар огт мэдэхгүй байна.

Ерөнхийд нь авч үзвэл, Монгол улсын 15-64 насны хүн амын ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг хангалтгүй, сонссон төдий ойлголттой байгаа ба улмаар эрүүл мэндийнхээ төлөө зөв шийдвэр гаргах эерэг хандлага бүрдээгүй байна. Ялангуяа, эрэгтэйчүүд, залуу насны хүмүүст эрсдэлт зан үйл, өөрийн хяналт, өвчлөх эрсдлийн талаар мэдлэг дутмаг, зөв үзэл бодол төлөвшөөгүй байна.

Нийт хүн амын зүрх судасны өвчин, чихрийн шижин, хөх, умайн хүзүүний хорт хавдар, эдгээрээс урьдчилан сэргийлэх арга замуудын талаарх ойлголт хангалтгүй, өөрийн хяналт маш сул, амьдралын хэв маягийн өөрчлөлтөөр өвчнөөс сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар эерэг хандлага бүрдээгүй, итгэл үнэмшил багатай байна.

Иймээс, нийт хүн амд, үүний дотор залуучуудад чиглэсэн ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлс, эрүүл мэндийн нөлөөллийн талаар энгийн, тодорхой, ойлгомжтой мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг боловсруулж, түгээх, өөрөө өөртөө хяналт тавих арга замуудын талаар тодорхой заавар зөвлөмжүүдийг боловсруулж сурталчлах, дэмжих орчинг бий болгох ажлуудыг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Олон нийтэд түшиглэсэн, амьдралын хэв маягийн өөрчлөлтөөр өвчлөхөөс сэргийлэх, өвчлөх эрсдлийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг дэмжиж, хүн амд нотолгоотой, хэрэгжүүлж болохуйц арга замуудыг санал болгох, улмаар цаашид үр дүнтэй ажил, санаачлагуудыг дэмжин дэлгэрүүлэх шаардлага байгааг судалгааны дүн харуулж байна.